

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2017 оны 1 дүгээр сарын 4-  
ний өдөр

Улаанбаатар хот

### **Дугаар 4 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Архивын тухай хуулийн 9.2.3, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2006 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсүгэй.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 5 дахь хэсэгт “4. Дөрөвдүгээр үе шат (2017-2020 он /дунд хугацаа/)” гэж, мөн хэсэгт “5.4. Дөрөвдүгээр үе шат (2017-2020)-нд Үндэсний төв архив, төрийн архивуудад хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримт, кино, гэрэл зураг, дуу авиааны баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим архив үүсгэх ажлыг зохион байгуулна.” гэж тус тус нэмсүгэй.
3. Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 5 дахь хэсгийн “дараах 2 үе шаттай” гэснийг “дараах үе шаттай” гэж өөрчлөн найруулсугай.
4. “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дөрөвдүгээр үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтод даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Хууль зүй, дотоод хэргийн сайд

С.БЯМБАЦОГТ

**“ТӨРИЙН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР“-ИЙН ДӨРӨВДҮГЭЭР ҮЕ ШАТ  
-НД ГҮЙЦЭТГЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ  
(2017-2020)**

№	Гүйцэтгэх арга хэмжээ	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	Архивын салбарт мөрдөгдөж буй арга зүйн баримт бичгүүдийг Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөртэй уялдуулан шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх	2017-2020	АЕГ, ХЗДХЯ, Төрийн архивууд	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Байгууллагын архивууд
2	Үндэсний төв архив, төрийн архивуудад хадгалагдаж буй цаасан суурьтай баримт, кино, гэрэл зураг, дуу авианы баримтаас мэдээллийн эрэлт хэрэгцээ ихтэй болон хими, физик шинж чанарын хувьд эхний <u>зэлжинд цахимжуулах</u> шаардлагатай хөмрөгүүдэд сэдэвчилсэн боловсруулалт хийх	2017-2020	АЕГ, Төрийн архивууд	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Байгууллагын архивууд
3	Төрийн архивын мэдээллийн нэгдсэн системийн программ хангамжийг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэх	2017-2018	АЕГ, ХЗДХЯ, МХХТГ, Төрийн архивууд	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ,
4	Төрийн архивт хөмрөг үүсгэгч төрийн байгууллагуудад ашиглагдах архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг программ хангамж боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэх	2018-2019	АЕГ, ХЗДХЯ, МХХТГ, Төрийн архивууд	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Байгууллагын архивууд
5	Монгол Улсын 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын баримтын мэдээллийн санг ашиглах программ хангамж боловсруулах, мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээлэл лавлагаа, магадлагаанд ашиглаж эхлэх	2017	АЕГ, ХЗДХЯ	Төрийн архивууд
6	Архивын лавлагаа, магадлагааг үнэт цаасан дээр мэдээллийн сангаас хэвлэх программ хангамжийг боловсруулан, хэрэглээнд нэвтрүүлж, онлайн үйлчилгээний горимд оруулах	2017-2020	АЕГ, ХЗДХЯ	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Төрийн архивууд
7	Кино, гэрэл зураг, дуу авианы баримт архивт хадгалагдаж буй 1990 оноос өмнө улсын төсвийн хөрөнгөөр бүтээгдсэн 35 мм-ын хальсан дээрх уран сайхны киног цахим хэлбэр /HD формат/-т шилжүүлэх	2017-2020	АЕГ, ХЗДХЯ	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Төрийн архивууд

8	Дуу авианы 6,25 мм-ын соронзон хальсан дээрх Монголын радиогийн алтан фондын 920 хадгаламжийн нэгж баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх	2017-2020	АЕГ, ХЗДХЯ	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Төрийн архивууд
9	Гэрэл зургийн 80.000 хадгаламжийн нэгж баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээлэл, лавлагаанд ашиглах	2017-2020	АЕГ, ХЗДХЯ	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Төрийн архивууд
10	Үндэсний төв архивт хадгалагдаж буй 50 байгууллагын 1970-2015 оны удирдлагын баримтыг цахимжуулах замаар цахим мэдээллийн санг өргөтгөж, уншлагын танхимаар болон лавлагaa, мэдээлэлд ашиглуулах.	2017-2020	АЕГ, ХЗДХЯ	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Төрийн архивууд
11	Төрийн архивуудад хадгалагдаж буй баримтаас эхний ээлжинд цахимжуулах шаардлагатай баримтын 30%-ийг цахим хэлбэрт шилжүүлэн, архивын цахим мэдээллийн хоёрдогч мэдээллийн сан үүсгэх	2017-2020	АЕГ, Төрийн архивууд	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ,
12	Архивын цахимжуулсан баримтын мэдээллийн сан үүсгэж, эрэлт хайлтын тогтолцоо, цахим үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх замаар төрийн архивын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй болгох	2017-2020	АЕГ, Төрийн архивууд	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, Байгууллагын архивууд
13	Цахим албан хэрэг хөтлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх, цахим архивын мэдээллийн сан үүсгэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай гэрээт архивч-операторчын цалингийн сан, техник хэрэгсэл, тооног төхөөрөмжөөр хангах зардлыг жил бүрийн төсөвт тусгах	2017-2020	СЯ, ХЗДХЯ, АЕГ	Яам, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ, төрийн байгууллагууд

---оо---